




ХУШААТ СУМ



Хушаат сум нь анх 1931 онд байгуулагдан 1956 онд сум татан буугдаж Цагаантолгойн Энхтал тасаг болж 1987 онд дахин шинээр байгуулагдсан. Даагат, Мөнхтолгой 2 багт нийт 576 өрхөд 1989 хүн ам амьдарч байна. Нийт газар нутгийн хэмжээ 201015 га. Үүнээс ХАА-н газар 152308 га, ойн сан бүхий газар 34,0 га, усан сан бүхий газар 175 га, улсын тусгай хэрэгцээний газар 13100 га, тосгон суурингийн газар 568,7, дэд бүтцийн 771,5 га газартай.

Хушаат сумын нутаг дэвсгэрт 1720 онд байгуулсан Их хүрээний Усансээр дэх туурь, хөшөө дурсгал, Баржгар улааны өвөр, Лам захын өвөр, Ишгэнт, Бумбат тохой, сумын төвийн хойд талаар Түрэгийн үеийн 90 гаруй хиргисүүр, байгалийн чимэг болсон Дуут хад уул, Эмчилгээний зориулалттай баталгаажсан Армогой, Асмалжингийн рашаанууд, Тойлбын соёмбо зэрэг түүх дурсгалын газруудтай.



ГАЗАР ТАРИАЛАН, МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ



72988 толгой малтай ба адуу 2977, үхэр 9899, хонь 35755 ямаа 24357 толгой байна. Нийт 573 өрх байгаагийн 287 малтай өрх байна. Сумын хэмжээнд 33 малчны бүлэгтэй. Казакын цагаан толгойн үүлдрийн махны чиглэлийн үхэр өсгөн үржүүлдэг. 2016 оноос герефорд үүлдрийн үхэр, 2017 оноос «Mercury corps» төслийн хүрээнд казакын цагаан толгойт үүлдрийн үхрийнхээ чанар үүлдэр угсааг сайжруулах ажлыг эрчимтэй хийж байна.



Суманд үр тарианы 22 ААН төмс хүнсний ногооны чиглэлээр 8 ААН, 55 иргэн нийт 22,0 мянган га тариалангийн талбай эзэмшин үйлдвэрлэл явуулж сүүлийн жилүүдэд түүхэн дээд амжилтыг тогтоон 14508 га-с 35009 тн үр тариа, 275,6 га-гаас 4242,0 тн төмс, 161,2 га-гаас 1860,0тн хүнсний ногооны ургац хураан авч байна. Мөн газар тариалангийн салбарт Монгол улсыг төмсний элит үрээр хангах төмсний "элит үр" үржүүлэх үйл ажиллагаа явуулж байна.



Хушаат сумаас «Улсын аварга тариаланч хамт олон» 3, «Улсын аварга тариаланч 12 төрөн гарсан».

